



ЭРҮҮЛ  
МЭНДИЙН ЯАМ



# СҮРЬЕЭ...

## ТА САНАА ЗОВОХ ХЭРЭГГҮЙ

*Эмэнд тэсвэртэй сүрьеэгээр өвчилсөн  
хүмүүст зориулсан өврийн лавлах*

Улаанбаатар хот





ЭРҮҮЛ  
МЭНДИЙН ЯАМ



# СҮРЬЕЭ...

## ТА САНАА ЗОВОХ ХЭРЭГГҮЙ



***Эмэнд тэсвэртэй сүрьеэгээр өвчилсөн  
хүмүүст зориулсан өврийн лавлах***

Улаанбаатар хот

# СҮРЬЕЭ...

## ТА САНАА ЗОВОХ ХЭРЭГГҮЙ

***Эмэнд тэсвэртэй сүрьеэгээр өвчилсөн  
хүмүүст зориулсан өврийн лавлах***

- Эхийг боловсруулсан: **Д.Наранзул**  
Хүний их эмч, Анагаах ухааны доктор
- Д.Доржмаа**  
Хүний их эмч, Анагаах ухааны магистр
- Р.Дорждэрэм**  
Хүний их эмч, Анагаах ухааны магистр
- Хянасан: **Д.Энхмандах**  
Хүний их эмч, Клиникийн профессор
- П.Насанжаргал**  
Хүний их эмч, Клиникийн профессор

## СҮРЬЕЭ... ТА САНАА ЗОВОХ ХЭРЭГГҮЙ

Сүрьеэ гэхээр та болон танай гэр бүлийнхэн гайхаж, бас санаа зовсон байж магадгүй. Сүрьеэ нь тийм ч ховор өвчин биш юм. Одоо дэлхий дахинд жил бүр 10 сая гаруй хүн сүрьеэгээр өвчилж, 2 сая орчим хүн энэ өвчний улмаас амь насаа алдаж байна. Монгол улсад жил бүр 4000 гаруй хүн сүрьеэгээр өвчилж, 200 орчим хүн нас барж байна. Тиймээс дэлхий дахинд болон Монгол улсад одоо ч сүрьеэ өвчин хамгийн их тархсан халдварт өвчний нэг хэвээр байна. Сүүлийн жилүүдэд эм эдгээж дийлэхгүй сүрьеэгийн нян илэрч, хүндрэх тохиолдол гарч байна.

Дэлхий дахинд сүрьеэ өвчний тархалтыг зогсоох бодлогын гол үндэс нь: “өвчилсөн хүнийг эдгэрүүлэх” гэсэн цогц бодлого юм. Эмэнд тэсвэртэй сүрьеэгээр өвчилсөн хүмүүсийг 9-24 сар эмчилдэг бөгөөд та бүхнийг тууштайгаар эмээ ууж эмчилгээгээ бүрэн хийлгэхийг эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэгчид **Уриалж** байна.

Таныг хурдан эдгэрч эрүүл болоход дэмжлэг болох энэхүү өврийн лавлахыг 4 дэх удаагаа шинэчлэн гаргаж байна. Таны сэтгэлийг зовоосон олон асуудалд хариулахын тулд хэрэгтэй гэсэн сүрьеэ өвчний талаарх мэдээллийг оруулж, мөн энэ өврийн лавлахын арын нүүрэнд эмчилгээний болон шинжилгээний чухал хүснэгтийг хавсарган хүргэж байна.

Монгол улсад сүрьеэгийн оношлогоо, эмчилгээ үнэ төлбөргүй байдаг бөгөөд таны уух эмийн зардлыг манай улсын Засгийн газар болон олон улсын байгууллагын тусламжаар худалдан авч таны сайн сайхны төлөө зориулж байна. Эмэнд тэсвэртэй сүрьеэгээр өвчилсөн нэг хүний эмийн зардал нь 3.5-9 сая гаруй төгрөг байдаг. Энэ дэлхий ертөнц дээр үнэгүй юм гэж байдаггүй. Таныг эмч, сувилагчийн зааврын дагуу өдөр бүр эмээ ууж, хурдан эдгэрч эрүүл болохыг хүсье.

Д.Наранзул, Анагаах ухааны доктор

Халдварт өвчин судлалын үндэсний төвийн

Халдварт өвчний тандалт сэргийлэлт эрхэлсэн дэд захирал

## ЯАГААД СҮРЬЕЭ ӨВЧНӨӨР ӨВЧИЛСӨН ВЭ?

Энэ асуулт сүрьеэгээр өвчилсөн хүн бүрт л бараг гардаг байх... Сүрьеэ нь амьсгалын замаар халдварладаг өвчин юм.

Та хаа нэг газар, хэн нэгэн хүнээс ялгарсан сүрьеэгийн нянг амьсгалж, уг нян таны уушгинд үржиж олширч эхэлдэг. Сүрьеэ өвчин нь “ханиалгах, цэр гаргах, ядрах, бага зэрэг халуурах” зэрэг жирийн ханиад, томуутай төстэй шинж тэмдгээр эхэлдэг. Өвчин цаашид хүндрэх тусам цэртэй хамт сүрьеэгийн нян гадагшилна. Өвчтөнийг ханиалгах, найтаахад гадагш цацагдана. Тэр нь хүний нүдэнд үл үзэгдэх маш жижиг бөгөөд ханиалгахад 1.5 м, найтаалгахад 3.5 м орчим цацагдаж байдаг. Ийм маягаар сүрьеэ нь хүнээс хүнд агаараар дамжин халдварладаг өвчин юм.

**Хүний биеийн эсэргүүцэл сулрах нь сүрьеэгээр өвчлөхөд хүргэдэг.**

Хүнд хүчир ажил хийх, нойр, хоол дутуу байх, ядрах, амьдарлын буруу хэвшил, хорт зуршил нь хүний биеийн эсэргүүцэх чадварыг сулруулах ба энэ үед халдвар авбал сүрьеэгээр амархан өвчилдөг. Мөн эрүүл мэндийн бусад шалтгаан ч сүрьеэгээр өвчлөхөд нөлөөлдөг. Чихрийн шижин, ХДХВ/ДОХ, ходоодны өвчин болон ходоодны мэс засал хийлгэсэн, бөөрний архаг өвчин, хорт хавдрын эмчилгээ хийлгэж байгаа, уушгины архаг өвчинтэй хүмүүс анхаарах шаардлагатай байдаг.

**Сүрьеэгийн нянгийн халдвар авсан хүн бүр сүрьеэгээр өвчилөхгүй**

Амьсгалын замаар орсон нян нь уушгинд үржиж эхэлсэн ч сүрьеэгээр өвчилсөн гэсэн үг биш. Дархлалын системийн нөлөөгөөр сүрьеэгийн нян унтаа буюу идэвхгүй байдалд шилждэг. Сүрьеэгийн нянгийн халдвар авсан хүмүүсийн 10 хувь нь өвчилдөг.

Сүрьеэгээр өвчлөх нь халдвар авснаас хойш богино хугацаа (0.5-2 жил)-нд илрэх, мөн урт хугацаа (5, 10, 20 жил)-ны дараа илрэх гэсэн 2 янз байна. Богино хугацаанд сүрьеэгээр өвчлөх нь их хэмжээний нянгийн халдвар авах, биеийн эсэргүүцэл суларсан үед тохиолдоно. Энэ нь хүүхэд болон залуучуудад элбэг. Удаан хугацааны дараа сүрьеэгээр өвчлөх гэдэг нь дээр үед халдварласан боловч тухайн үедээ мэдэгдэхгүй уушгины хаа нэгтэй нуугдаж байгаад олон арван жилийн дараа насжилт, хүнд хэлбэрийн мэс засал зэргээс биеийн тамир тэнхээ доройтсон үед нян нь дахин сэргэж, өвчлүүлэх ба өндөр настангуудад их тохиолддог.



## ЭМЭНД ТЭСВЭРТЭЙ СҮРЬЕЭ ӨВЧНИЙ ТУХАЙ

Сүрьеэгийн эсрэг эмийг эмчийн зааврын дагуу тохирсон тун хэмжээгээр уухгүй бол сүрьеэгийн нян эмүүдэд тэсвэртэй болно. Энэ нь сүрьеэгийн эсрэг хамгийн сайн эмүүд нянг устгаж чадахгүй боллоо гэсэн үг юм.

### Эмэнд тэсвэржилт нь ямар хүмүүст тохиолдох эрсдэлтэй вэ?

- Эмэнд тэсвэртэй сүрьеэтэй өвчтөний өрхийн болон ойрын хавьтал
- Эмийг эмчийн өгсөн тун заавраар хэрэглэхгүй байх
- Өмнө нь сүрьеэгээр өвчилж байсан ба эмчилгээг бүрэн төгс хийлгээгүй, эмчилгээ тасалсан
- Эмэнд тэсвэртэй сүрьеэгийн өвчлөл өндөртэй газар ажиллах, амьдрах

### Сүрьеэгийн нян эмэнд тэсвэржих шалтгаан юу вэ?

Эмэнд тэсвэртэй сүрьеэг хүн өөрөө үүсгэдэг. Үүний гол шалтгаан нь:

- Сүрьеэгийн эсрэг эмчилгээг хяналтгүй хийлгэх
- Сүрьеэгийн эмчилгээг дутуу хийлгэх, таслах
- Чанаргүй эм хэрэглэх
- Эмч, сувилагчийн өгсөн заавар зөвлөмжийг бүрэн дагаж мөрдөхгүй байх

Эдгээр шалтгааны улмаас та болон танай гэр бүлийн гишүүн эмэнд тэсвэртэй сүрьеэгээр өвчилж болно.

### Эмэнд тэсвэртэй сүрьеэ хэр аюултай вэ?

**Нас баралт:** Эрт оношлуулж, эмчилгээг бүрэн хийлгээгүй тохиолдолд үхэлд хүргэх аюултай.

**Өвчлөл:** Өвчний явц удааширч, гэр бүл, найз нөхөд, нийгэм хамт олонд эмэнд тэсвэртэй сүрьеэгийн нян халдварлуулан өвчлүүлдэг.

**Зардал ихтэй:** Эмэнд тэсвэртэй сүрьеэгийн эмчилгээ өндөр үнэтэй

- Эмчилгээний үргэлжлэх хугацаа урт 9-24 сар
- Зарим хүнд эмийн гаж нөлөө илэрч болно
- Удаан хугацаагаар эмнэлгт хэвтэх, хөдөлмөрийн чадвар алдсанаас өрхийн орлого буурдаг.

### 1 өвчтөнг эмчлэхэд гардаг шууд зардал:

- 10 сая гаруй төгрөгөөр нэг өвчтөнийг эмчилдэг

## ЭМЭНД ТЭСВЭРТЭЙ СҮРЬЕЭ ХЭРХЭН ХАЛДВАРЛАДАГ ВЭ?



Эмэнд тэсвэртэй сүрьеэ нь амьсгалын замаар хүнээс хүнд халдварладаг.

- Уушгины сүрьеэтэй өвчтөн ярих, дуулах, хашгирах, найтаах ялангуяа ханиалгахад сүрьеэгийн нян агуулсан маш жижиг, олон арван дуслыг агаарт цацдаг.
- Уушгины сүрьеэтэй өвчтөн ханиах (3500 ширхэг) болон найтаахад (1 сая ширхэг) их хэмжээний савханцар агуулсан дуслууд богино хугацаанд агаарт цацагдаж тэдгээр нь уурших хүртлээ хөвж байдаг.
- Ханиалгахад 5 минут чанга ярихад ялгарахтай тэнцүү тооны нян агуулсан жижиг дуслууд агаарт цацагддаг.
- Бохирлогдсон агаараар эрүүл хүн амьсгалж халдвар авч өвчилдөг.

### Та эмэнд тэсвэртэй сүрьеэгээр өвчилсөн тохиолдолд юу хийх вэ?

- Эмэнд тэсвэртэй сүрьеэгээр өвчилсөн гэдгээ гэр бүлдээ хэлэх
- Таны онош батлагдсан бол цаг алдалгүй эмчилгээнд хамрагдах нь нэн чухал
- Та харьяа аймаг, дүүргийн сүрьеэгийн диспансерт хандаж эмчилгээнд хамрагдах



Та эмэнд тэсвэртэй сүрьеэгийн эмчилгээнд хамрагдахын тулд дараах бэлтгэл хангасан байх шаардлагатай.

#### Хувийн бэлтгэл

- Таны эмчилгээ удаан хугацаагаар үргэлжлэх учир амьдрах, оршин суух гэрийн хаягийг тодорхой болгох
- Эмэнд тэсвэртэй сүрьеэгийн эрчимт шатны эмчилгээг эмнэлэгт хэвтүүлэн, таны цэрний өсгөвөрлөх шинжилгээ дараалан 2 удаа сөрөг болтол хийх тул энэ хугацаанд гэр бүлийн асуудал (хүүхдийн сургууль, цэцэрлэг, асран хамгаалах хүн, орон байр, халамж үйлчилгээ) бүрэн зохицуулах
- Эмэнд тэсвэртэй сүрьеэгийн эмчилгээнд хамрагдахыг өвчтөн болон гэр бүлийн гишүүн зөвшөөрсөн байх
- Гэр бүлийн гишүүд хавьтлын урьдчилан сэргийлэх үзлэгт бүрэн хамрагдсан байх

**Зайлшгүй бүрдүүлэх шинжилгээ**

- Цэрний түрхцийн шинжилгээний хариу
- Цэрний өсгөвөр, эмийн мэдрэг чанарын шинжилгээний хариу
- Цээжний рентген зураг
- Цусны дэлгэрэнгүй шинжилгээ
- Элэгний үйл ажиллагааны сорил
- Шээсний ерөнхий шинжилгээ
- Зүрхний цахилгаан бичлэг
- Бамбай булчирхайн дааврын шинжилгээ
- Харааны чадал, өнгө ялгах сорил
- Сонсголын бичлэг
- Төрөх насны эмэгтэйчүүдэд жирэмснийг тодорхойлох сорил
- Удаан хугацаагаар ууж хэрэглэдэг эм байвал түүнийг эмч нарт заавал хэлнэ.

**ЭМЧ НАРЫН ЗӨВЛӨГӨӨНИЙ ТУХАЙ**

Эмч нарын хамтарсан зөвлөгөөн 7 хоногт нэг удаа, Пүрэв гаригийн 10 цагаас ХӨСҮТ-д болдог. Мөн хөдөө, аймаг орон нутагт эмч нарын зөвлөгөөн хийнэ. Зарим тохиолдолд цахим зөвлөгөөн зохион байгуулдаг.

- Эмч нарын хамтарсан зөвлөгөөнөөр эмэнд тэсвэртэй сүрьеэтэй өвчтөнийг шинээр эмчилгээнд оруулах, эмчилгээний горим өөрчлөх, эмийн гаж нөлөө, эмчилгээний явцын хяналт болон эмчилгээний эцсийн үр дүнг тооцох зэрэг асуудлыг хэлэлцдэг.

**Анхааруулга:**

Эмч нарын хамтарсан зөвлөгөөний дараа эмчлэгч эмч нь танд болон танай гэр бүлд дараах зүйлийг тайлбарлан өгөх үүрэгтэй. Үүнд:

- Таны биеийн байдал
- Таны онош, шинжилгээний хариу, үр дүн, дүгнэлт, цаашдын тавилан, явц
- Санал болгож буй эмчилгээний хугацаа, үр дүн
- Эмчилгээний үед гарч болох эмийн гаж нөлөө
- Эмчилгээ таслах, таггалзсан тохиолдолд гарч болох эрсдлүүд
- Гэр бүлийн хавьтлын үзлэг шинжилгээ, түүний ач холбогдол
- Гэр бүл төлөвлөлт гэх мэт

## Эмнэлэгт хэвтэх үеийн хувийн бэлтгэл

Эмч таныг эмнэлэгт хэвтэн эмчлүүлэхийг зөвлөсөн тохиолдолд **ТА** хувийн бэлтгэлээ сайтар хангаснаар тав тухтай байх боломж бүрдэнэ.

### Танд өгөх 10 зөвлөгөө

- **Бичиг баримт:** Хүчинтэй биеийн байцаалт (иргэний үнэмлэх, эрүүл мэндийн даатгалын дэвтэр, эрүүл мэндийн карт) болон танд хэрэг болох бичиг баримтыг нэг хавтсанд хийж авч ирэхийг зөвлөж байна.
- **Мөнгө:** Сонин хэвлэл, ариун цэврийн хэрэглэл авч болох тул бага хэмжээний мөнгө биедээ авч хэвтэж болно. Харин үнэт эдлэл, их хэмжээний мөнгө биедээ авчрахгүй байхыг зөвлөж байна.
- **Хувцас:** Эмнэлгийн нөхцөлд биед эвтэй, дулаан, чийг татахааргүй хөвөн давуун өмд, цамц, дулаан оймс, хөлд эвтэй шаахай өмсөх нь танд илүү тухтай байх болно.
- **Нүдний шил:** Та нүдний шил зүүдэг бол ойрын, холын харааны шилээ авахаа мартуузай.
- **Цаас үзэг:** Эмч, эмнэлгийн мэргэжилтний өгсөн зөвлөгөө болон шаардлагатай гэж үзсэн зарим зүйлээ тэмдэглэж болох тул цаас, үзэг бал авч болно.
- **Гар утас эсвэл утасны карт:** Шаардлагатай үед ярих утасны карт, нэгж, өөрийн утсаа авч хэвтэж болно. Харин утсаар ярихдаа бусдын амгалан тайван байдлыг хүндэтгэн нам дуугаар ярих, утасны дууг чичиргээнд дээр тавихыг зөвлөж байна.
- **Ариун цэврийн хэрэглэл:** Өдөр тутмын хувийн ариун цэврийн хэрэгсэл (шүдний сойз, оо, саван, биеийн тос, сам, шампунь, 00 цаас, аяга халбага зэрэг)–ийг авч хэвтээрэй. Харин эмнэлэгт хурц үнэртэй сүрчиг хэрэглэхгүй байхыг зөвлөж байна.
- **Таны цагийг үр ашигтай өнгөрөөх зүйлс:** Цагаа зохистой өнгөрөөхийн тулд эмчилгээ, оношлогоо, зөвлөгөөний цагаас бусад үед унших ном, сэтгүүл, эсвэл хатгамал, нэхмэл зэрэг өөрийн сонирхдог зүйлээ авч хэвтэж болно. Харин эмнэлэгт хүмүүс цуглуулж хөзөр тоглох, дуу хөгжим чанга тавих зэргээр бусдад саад болж болохгүйг анхаарах хэрэгтэй.
- **Зураг:** Жижиг жаазтай өөрийн хайртай зургаа авч хэвтэж болно.
- **Цахилгаан хэрэгсэл:** Эмнэлгийн дотоод журамтай урьдчилан танилцаад хэрэв зөвшөөрсөн заалт байгаа бол зөөврийн компьютер, ус буцалгагч зэргийг биедээ авч хэвтэж болно.

## Та эмнэлэгт ямар дэглэм баримтлах вэ?

### Та дараах зүйлсийг анхаарах шаардлагатай

- Та эмнэлэгт байх хугацаанд амны хаалт байнга зүүж, түүнийг угааж, цэвэрлэж байна.
- Бусад үйлчлүүлэгч болон эрүүл мэндийн ажилтны амгалан тайван байдлыг эрхэмлэх үүднээс тамхи татах, архи, согтууруулах ундаа хэрэглэхийг хатуу хориглоно.
- Бусад өвчтөний өрөөгөөр дэмий сэлгүүцэх, нийлж тоглох, гадны хүн орохыг хориглосон тасаг, хэсэг рүү зөвшөөрөлгүй орохыг хориглоно.
- Эмнэлэгт хэвтэж байх хугацаанд та түр гарах зайлшгүй шаардлага гарвал эмчээсээ зөвшөөрөл авч тухайн өдрийн ээлжийн сувилагчид тэмдэглүүлсэн байна.
- Чөлөөний хугацаа 4 цагаас хэтрэхгүй байна. Аюулгүй байдал, эмчилгээний чанарыг сахих үүднээс эмчлүүлэгчийг эмнэлгээс гадуур хонох зөвшөөрөл олгохгүй.
- Телевизорыг өглөө 09.00-21.00 цагийн хооронд үзэхийг зөвшөөрнө. Бусад эмчлүүлэгчийн амгалан байдлыг хангах үүднээс 21.00 цагаас хойш телевизор үзэхгүй байх ёстой.
- Эргэлтээр ирсэн хүмүүстэй уулзалтын өрөө, зааланд уулзана.
- Нохой, муур, гэрийн бусад тэжээвэр амьтан авчрахыг хориглоно.

## ЭМЭНД ТЭСВЭРТЭЙ СҮРЬЕЭГИЙН ЭМЧИЛГЭЭНИЙ ТАЛААР ТАНЫ МЭДВЭЛ ЗОХИХ ЗҮЙЛС

Сүрьеэгийн эмчилгээ бусад үрэвслийн эсрэг эмчилгээг бодвол харьцангуй удаан хугацаа шаардахаас гадна 2 үе шатаар хийгдэнэ. Эмчилгээний эрчимт шат 4-8 сар, үргэлжлэх шат 5-16 сар, нийт үргэлжлэх хугацаа 9-24 сар байх ба 5-7 төрлийн эмийг хавсран хэрэглэнэ.



## Эмэнд тэсвэртэй сүрьеэгийн эсрэг эмийг өдөр бүр тогтмол уух шаардлага юу вэ?

- Эмэнд тэсвэртэй сүрьеэгийн нянг бүрэн устгахад 9-24 сарын эмчилгээ шаардлагатай байдаг.
- Танд эмчилгээ эхэлснээс хэдхэн долоо хоногийн дараагаас бие тань сайжирч зовиур шаналгаа арилж эрүүл болсон мэт санагдаж болно. Гэвч эмэнд тэсвэртэй сүрьеэгийн нянгууд таны биед амьд байсаар л байгаа гэдгийг мартаж болохгүй.
- Эмээ өдөр бүр тогтмол уугаагүйгээс сүрьеэгийн нян таны ууж буй сүрьеэгийн эмүүдэд тэсвэржиж, илүү хүнд хэлбэрийн буюу маш олон эмэнд тэсвэртэй сүрьеэгээр өвчлөх, нас барах аюултай үр дагавар таныг хүлээж байгаа гэдгийг битгий мартаарай.
- Таны өвчин сэдэрч гэр бүл, хамаатан садан, найз нөхөд болон хамт олонд эмэнд тэсвэржсэн сүрьеэгийн нянгийн халдвар тарааж эхэлдэг.
- Иймд та эмчийн зааврын дагуу эмээ өдөр бүр тогтмол уух шаардлагатай



### Онцгой анхааруулга:

Та эмчилгээг 2-3 удаа тасалсан тохиолдолд бүрэн эдгэрэх магадлал буурна гэдгийг анхаарах хэрэгтэй.

## Та эмээ уухаа мартахгүйн тулд юу хийх вэ?

Эмэнд тэсвэртэй сүрьеэгийн эсрэг эмийг удаан хугацаагаар уух нь танд амар биш байж болох юм. Гэхдээ өдөр бүр эмээ ууснаар та бүрэн эдгэрэх боломжтой. Одоо таны гарт байгаа эмүүд л таны өвчнийг бүрэн эдгэрүүлнэ.

- Эмийг өдөр бүр тогтсон цаг ууж байх, энэ талаар эмчлэгч эмч, сувилагч нартайгаа сайтар ярилцаж цагаа тохирох
- Гэр бүлийн гишүүдийн хэн нэгэн эмээ уухыг тогтмол сануулж байх
- Гар утсан дээрээ эмээ уух цагаа тохируулж дуут дохио тавих
- Эсвэл цаг дээр эмээ уух цагаа тохируулж сэрүүлэг тавих
- Та ажлын өрөө, ширээ, гэртээ эмээ уухаа сануулсан тэмдэглэлийг хуанли дээр хийж болно
- Та гал тогоо, ариун цэврийн өрөөнд эмээ уухыг сануулсан ямар нэг тэмдэглэл тавьж болно
- Арын нүүрэнд байгаа тариа тариулж, эмээ ууснаа тэмдэглэх хэсэгт өдөр бүр тосон балаар бичиж байгаарай

## ЭМЭНД ТЭСВЭРТЭЙ СҮРЬЕЭГИЙН ЭМЧИЛГЭЭНД ХЭРЭГЛЭЖ БҮЙ ЭМИЙН БЭЛДМЭЛҮҮД

### Тарилгын бэлдмэл:

- Канамицин
- Капреомицин
- Амикацин



Эдгээр нь нянг устгах үйлчилгээтэй эмүүд юм. Эдгээр эмүүд нь булчинд тарих зориулалтаар ариутгасан цагаан нунтаг байдлаар битүү таглаатай шилэн саванд савлагдсан байдаг.

Эмийг 0.9%-ийн давсны хүчлийн уусмал эсвэл тарилгын 2 мл усанд уусгаж хэрэглэнэ. Бүрэн уусгахын тулд 2-3 минут байлгана.

Эрчимт шатны эмчилгээний үед дээрх 2 бэлдмэлийн аль нэгийг сонгон өдөр бүр булчинд тарьж хэрэглэнэ. Ямар тун хэмжээгээр тарихыг эмчлэгч эмч шийдвэрлэнэ.

### Нэмэлт мэдээлэл:

Тарих талбайг сольж байвал хэсэг газар бэрсүү үүсэхээс сэргийлнэ.

#### Онцгой анхааруулга



- Эмчилгээний эрчимт шат нь таны эдгэрэх оргил үе юм.
- Тарилгын бэлдмэлийг хамгийн багадаа 4-8 сар хэрэглэх бөгөөд эмчилгээнээс хасах асуудлыг эмч нарын хамтарсан зөвлөгөөнөөр шийдвэрлэнэ.
- Өдөр бүр тариа тариулах нь танд хэцүү санагдаж болох ч үүнийг даван туулах ёстой.

Эмнэлгийн бус нөхцөлд мэргэжлийн бус хүнээр тариа тариулснаас буглаа үүсэх зэрэг хүндрэл гарч болохыг анхаарах хэрэгтэй.

#### ЛЕВОФЛОКСАЦИН

**Анхааруулга:** Явах хөдлөхөд шөрмөс татах өвдөх, булчин өвдөх, үеэр өвдөх, арьсан дээр жижиг тууралт гарах, толгой эргэх, сэтгэл түгших, арьс салст шарлах, суулгах, цээжээр өвдөх, зовиур илэрвэл эмчид хандана.

**Нэмэлт мэдээлэл:** Шингэн зүйл сайн уух. Хөнгөн цагаан агуулсан эм хамт хэрэглэхгүй байх. (Алмагель, Маалокс гэх мэт) Эмийг ууснаас 2-4 цагийн дараа төмөр, магни агуулсан мультивитамин уух нь эрдэс аминдэмийн дутагдлаас сэргийлэх ач холбогдолтой.

### КАНАМИЦИН

**Анхааруулга:** Сонсгол муудах, дүлийрэх, толгой эргэх, тэнцвэр алдагдах, арьсан дээр тууралт гарах, нүүр хавдах, амьсгалахад бэрхшээлтэй болох, шээсний гарц багасах, суулгах, хэвлийгээр хүчтэй өвдөх, булчин сулрах шинж тэмдэг илэрвэл эмчлэгч эмчдээ даруй хандаж зөвлөгөө авна.

### КАПРИОМИЦИН

**Анхааруулга:** Арьсан дээр тууралт гарах, халуурах, цус алдах амархан хөхрөх, сонсгол буурах, толгой эргэх, тэнцвэр алдагдах, шээсний гарц багасах, амьсгалахад бэрхшээлтэй болох, булчин сулрах зэрэг зовиур илэрвэл эмчлэгч эмчдээ хандаж үзүүлэх, зөвлөгөө авах шаардлагатай.

### ЭТИОНАМИД ЭСВЭЛ ПРОТИОНАМИД

**Анхааруулга:** Нүд өвдөх, бүрэлзэх, өнгө ялгах чадвар муудах, хөл гар хөших, өвдөх, гэнэтийн цус алдалт, зөөлөн эд хөхрөх, хувь хүний зан авир өөрчлөгдөх, арьс салст шарлах, шээс хар өнгөтэй гарах, дотор муухайрах, бөөлжих, толгой эргэх, эрчүүдийн хөх томрох зовиур илэрвэл хяналтын эмчдээ яаралтай мэдэгдэнэ. Та энэхүү өврийн лавлахын хавсралтанд байгаа нүдний өнгө ялгах сорилоор өөрийгөө хааяа шалгаж байгаарай.

**Нэмэлт мэдээлэл:** Эмийг жүржийн шүүс эсвэл сүүтэй хамт, мөн сүү уусны дараа уувал дотор муухайрахаас сэргийлнэ. Эмийг хоолтой хамт хэрэглэх. Витамин B6 уух нь чухал.

### ПАРА-АМИНОСАЛИЦИЛЫН ХҮЧИЛ (ПАСК)

**Анхааруулга:** Хэрвээ арьсан дээр тууралт гарах, хоолонд дургүй болох, ядрах, хар өнгөтэй баах, хэвлийгээр өвдөх зэрэг зовиур илэрвэл эмчлэгч эмчдээ даруй хандаарай.

**Нэмэлт мэдээлэл:** Манай улсад нунтаг бэлдмэлийг ихэвчлэн хэрэглэдэг. Эмийг бүрэн уусгаж уух хэрэгтэй. Энэ бэлдмэлийг хоолны дараа эсвэл сүүтэй хамт хэрэглэж болно. Зарим хүмүүс жимсний шүүстэй хамт хэрэглэх тохиолдол байдаг.

### АМОКСИЦИЛЛИН КЛАВУЛИНЫ ХҮЧИЛ

**Анхааруулга:** Арьсан дээр тууралт гарах, амьсгалахад бэрхшээлтэй болох, хүнд хэлбэрийн суулгалт илэрч байгаа бол эмчлэгч эмчдээ заавал хэлээрэй.

**ЦИКЛОСЕРИН ЭСВЭЛ ТЕРИЗИДОН**

**Анхааруулга:** Сэтгэл гутрах, өөртөө итгэлгүй, амьдрах сонирхолгүй болох, сэтгэл түгших, мартамхай болох, хувь хүний зан байдал өөрчлөгдөх, түрэмгий болох, тууралт гарах, толгой өвдөх зэрэг зовиур илэрвэл өөрөө төдийгүй ар гэрийнхэн нь анхаарч эмчлэгч эмчид яаралтай хэлэх хэрэгтэй. Гэхдээ энэ нь ховор тохиолддог.

**Нэмэлт мэдээлэл:** Ууж байгаа үед пиридоксин хамт хэрэглэх нь төв мэдрэлийн системд үйлчлэх нөлөөг бууруулж болдог. Энэ талаар эмчлэгч эмчээсээ зөвлөгөө аваарай.

**МЕРОПЕНЕМ**

**Анхааруулга:** Усархаг суулгах, арьсан дээр тууралт гарах, нүүр уруул хавдах, амьсгалахад бэрхшээлтэй болох зэрэг зовиур илэрвэл эмчид хандана.

**Нэмэлт мэдээлэл:** Клавулины хүчил агуулсан бэлдмэл заавал хамт уух ёстой. Энэ нь микобактерийн хананд үзүүлэх нөлөөг дэмждэг. Хэрэв клавулины хүчил хамт хэрэглэхгүй бол эмчилгээ үр дүнгүй болно. Үүнийг өвчтөн бүр сайтар ойлгох учиртай.

**МОКСИФЛОКСАЦИН**

**Анхааруулга:** Шөрмөс татах, булчин өвдөх, үеэр өвдөх, тууралт бижрүү гарах, зөөлөн эд хөхрөлт үүсэх, суулгах, сэтгэл түгших, толгой эргэх зэрэг зовиур илэрвэл эмчлэгч эмчдээ даруй мэдэгдэнэ.

**КЛОФАЗАМИН**

**Анхааруулга:** Цустай болон хар өнгөтэй баах, суулгах, арьс салст шарлах, дотор муухайрах, бөөлжих, хэвлийгээр өвдөх, сэтгэл гутрах, өөртөө итгэлгүй болох зэрэг зовиур илэрвэл өөрөө төдийгүй ар гэрийнхэн нь анхаарч эмчлэгч эмчид яаралтай хандана.

**Нэмэлт мэдээлэл:** Хоол идсэний дараа эмийг ууна. Нарны тос түрхэнэ. Арьсны өнгө хар-бор болох ч эмчилгээ дуусаад хэдэн сарын дараа хэвийн байдалд эргэж орно.

**ЭТАМБУТОЛ**

**Анхааруулга:** Өнгө ялгах чадвар буурах, нүд бүрэлзэх, хараа муудах, нүдээр өвдөх, замын хөдөлгөөнд оролцоход хүндрэлтэй санагдвал эмчлэгч эмчдээ мэдэгдээрэй.

### ЛИНЕЗОЛИД

**Анхааруулга:** Үе мөч мэдээ алдах, эрвэгнэх, тамирдах, өтгөн хатах, хар өнгөтэй баах, цус алдалт, шалтгаангүй ядрах сульдах, толгой өвдөх, бөөлжих, дотор муухайрах зовиур илэрвэл яаралтай эмчид хандана.

**Нэмэлт мэдээлэл:** Эмийг хоол идэх үед уувал ходоод хямрах нь бага байдаг.

### БЕДАКВИЛИН

**Анхааруулга:** Хэвлийн хэсгээр өвдөх, зүрх дэлсэх, арьс салст шарлах, салгалах, зүрх дэлсэх, мартамхай болох ухаан балартах зэрэг зовиур илэрвэл эмчлэгч эмчдээ яаралтай хандана.

**Нэмэлт мэдээлэл:** Хоол идсэний дараа болон хоолтой хамт ууж хэрэглэнэ. Архи хэрэглэхээс зайлсхийх хэрэгтэй. Архи нь эмийн гаж нөлөөг улам ихэсгэхэд нөлөөлдөг.

### ДЕЛАМАНИД

**Анхааруулга:** Зүрх дэлсэх, цээж өвдөх, ухаан балартах зэрэг зовиур илэрвэл эмчид яаралтай хандана.

### ИЗОНИАЗИД

**Анхааруулга:** Гар хөл ирвэгнэх, юм гүйж буй мэт санагдах, халуу оргих, сэтгэлээр унах, амьдрах утгагүй санагдах, хэт сэтгэл хөдлөл мэдрэгдвэл эмчдээ хандаарай.

### ПИРАЗИНАМИД:

**Анхааруулга:** Арьсаар тууралт гарах, арьс загатнах, үеэр өвдөж хавдах, нүдний салст болон арьс шар өнгөтэй болох, шээс хар бараан өнгөтэй болох, дотор муухайрах, бөөлжих, ядарч сульдах, хоолны дуршилгүй болох шинж илэрвэл эмчлэгч эмчдээ мэдэгдээрэй.

Эдгээр эмүүдээс 5-7 төрлийн эмийг сонгон эмчилгээний тусгай горимын дагуу таныг эмчилнэ. Тиймээс эмчлэгч эмч болон сувилагчаас танд аль эмийг нь хэрэглэж байгаа талаар асууж тодруулаарай. Мөн өөрийн ууж байгаа эмтэй холбоотой гарч ирэх аливаа өөрчлөлтийн талаар мэдлэгтэй байх нь таны эмчилгээний үр дүнд ихээхэн ач холбогдолтой юм.

## ЭМЧИЛГЭЭНИЙ ҮЕД ИЛРЭХ ГАЖ НӨЛӨӨНИЙ ТАЛААР ТАНЫ МЭДВЭЛ ЗОХИХ ЗҮЙЛС

Хэдийгээр хүн бүрт эмийн гаж нөлөө илрэхгүй боловч зарим өвчтөнд дараах шинж тэмдэг илэрч болно. Танд эдгээр шинж тэмдэг илэрч байвал эмч, сувилагчдаа заавал хэлээрэй.

- Бөөлжих
- Дотор муухайрах
- Ходоод өвдөх
- Толгой өвдөх
- Сонсгол буурах, дүлийрэх
- Тэнцвэр алдагдах
- Таталт өгөх
- Нүдний салст, арьсны өнгө шарлах
- Сэтгэл тавгүй болох, нойр өөрчлөгдөх, хийх дуртай зүйлээ хийх сонирхолгүй болох, найз нөхөдтэйгээ уулзахаас татгалзах, таагүй бодол толгойд эргэлдэх, ялихгүй зүйлд уурлаж бухимдах
- Үе мөч өвдөх, хавдах
- Гар, хөл бадайрах, өвдөх
- Биеэр тууралт гарах болон бусад шинж тэмдэг илэрч байвал эмчлэгч эмч, сувилагчдаа цаг алдалгүй хэлээрэй.



Эмчилгээний үед илэрч байгаа эмийн гаж нөлөөг бууруулах, арилгах эмчилгээнүүдийг хавсран хийлгэх хэрэгтэй. Ингэснээр таны цаашдын эмчилгээний үр дүнд сайнаар нөлөөлөх болно.

**Эмчийн заавраар эмчилгээг бүрэн хийлгэвэл:  
СҮРЬЕЭ ЭДГЭРДЭГ ӨВЧИН.**

### Анхааруулга:



- Хэрэв та эм уусаны дараа 30 минутын дотор бөөлжиж байгаа бол эмчдээ яаралтай хэлж арга хэмжээ авах ёстой.
- Энэ нь таны уусан эм биед чинь шингэж чадахгүй бөөлжилтөөр гарч байна гэсэн үг юм.
- Энэ байдал удаан хугацаагаар үргэлжилвэл таны эмчилгээний үр дүнд сөргөөр нөлөөлнө гэдгийг анхаарах хэрэгтэй

**Эмийн гаж нөлөө илэрсэн үед та юу анхаарах хэрэгтэй вэ?*****Та өөрийнхөө анхаарлыг өөр зүйлд төвлөрүүлэх нь чухал***

- Эмээ уусны дараа өөрийгөө тайвшруулах дасгал, бясалгал хийх
- Иогоор хичээллэх
- Унтаж амрах
- Ном, сонин, сэтгүүл унших
- Үгийн сүлжээ бөглөх
- Телевизор үзэх
- Хөгжим сонсох
- Интернэтээр аялах
- Зураг зурах
- Юм оёх, нэхэх
- Найз, гэр бүлтэйгээ утсаар ярих
- Гэрээ цэвэрлэх, юм угаах
- Цэцэг, ургамал арчлах
- Гадаа салхинд гарах зэргээр өөрийн хамгийн дуртай зүйлээ хийх хэрэгтэй



## ОЭТС БА СЭТГЭЦИЙН ЭРҮҮЛ МЭНД

Олон эмэнд тэсвэртэй сүрьеэ (ОЭТС)-гээр өвчилсөнөө сонсоод хүн бүрт сэтгэл санаа дундуур болох, айх, гайхах, оношоо хүлээн зөвшөөрөхгүй байх, уйлах зэрэг сэтгэлзүйн сөрөг хариу урвал илэрдэг.

ОЭТС-ийн эмчилгээ 9-24 сар үргэлжлэх бөгөөд энэ нь богино хугацаа биш юм. Эмчилгээний үед өвчтөний хэвийн амьдралд (гэр бүлийн харилцаа, найз нөхдийн харилцаа, ажил эрхлэлт, сургалт) нь тодорхой хэмжээгээр өөрчлөлт гарч, тэдгээртэй холбоотой олон асуудал үүсдэг. Энэ бүгд нь өвчтөний сэтгэлзүйд сөргөөр нөлөөлдөг.

ОЭТС-ийн улмаас танд ямар таагүй нөхцөл байдал үүссэн бэ?

.....

.....

.....

**Амьдрал сорилтоор дүүрэн.**

**Бидэнд тулгамдах асуудлууд биднийг өөрчлөгдөх ёстойг сануулж байдаг.**

Эмчилгээний хугацаанд өвчтөн 5-7 төрлийн 14-20 ширхэг эмийг өдөр бүр уудаг ба эм уусны дараа дотор муухай болох, огих, бөөлжих, толгой эргэх, үе мөчөөр өвдөх зэрэг гаж нөлөө илэрнэ. Эмийн гаж нөлөө нь өвчтөн эмээ уухгүй, эмчилгээгээ таслахад хүргэдэг.

ОЭТС-ийн эм уухын өмнө танд ямар бодлууд төрдөг вэ?

.....

.....

.....

Сүрьеэгийн эмүүд гаж нөлөө ихтэй хэдий ч сүрьеэгийн нянг утсгаж чадах давуу талтай. Иймд хичнээн хэцүү байсан ч та эмээ өдөр бүр уугаарай.

**Та чадна**

Нөхцөл байдлыг бодитоор хүлээн зөвшөөрч урт хугацааны эмчилгээнд сэтгэлээ бэлтгэх нь эдгэрэх хүсэл зорилгодоо амжилттай хүрэх анхны алхам юм.

Та өнөөдөр ямар мэдрэмжтэй байна вэ?

.....

.....

.....

Өдөр бүр олон ширхэг эм уух нь амаргүй ч эдгэрэх чин хүсэлдээ хөтлөгдөн хийж буй оролдлого юм.

Би өвчиндөө бууж  
өгөхгүй...

Би эдгэрчихээд  
энэ өвчнөөс болж  
алдсан бүх зүйлээ  
эргүүлэн олж авна

Намайг эдгэрүүлэх  
эмүүдээ  
би заавал ууна

Бурхан минь,  
эмчилгээгээ даван  
туулах эрч хүчийг надад  
хайрлаач

**Оролдлого бүхэн амжилттай болдоггүй.  
Гэхдээ оролдлого бол амжилтад хүрэх алхам юм**

ОЭТС-ээр өвчилсөн, эмчилгээнд хамрагдах ёстой гэдэгтээ хүн бүр харилцан адилгүй ханддаг.

**Хүлээн зөвшөөрөхгүй байх нь: Бүтэлгүй зам**

**ОЭТС-ээр  
өвчлөх**

- Оношоо хүлээн зөвшөөрөхгүй байх
- Эмчилгээнээс татгалзах
- Эмийг өдөр бүр уухгүй байх

- Өвчин хүндрэх
- Нас барах
- Халдварыг бусдад тараах

**Хүлээн зөвшөөрөх нь: Эрүүл байх зам юм**

**ОЭТС-ээр  
өвчлөх**

- Оношоо хүлээн зөвшөөрөх
- Эмчилгээнд хамрагдах
- Эмийг өдөр бүр уух

- Өвчин хүндрэхгүй
- Нас баралтаас сэргийлнэ
- Эдгэрч эрүүл болно
- Халдварыг бусдад тараахгүй

**Оношоо хүлээн зөвшөөрч, эмчилгээндээ хамрагдах нь  
эдгэрэлтэд хүрэх алхам юм**

ОЭТС-ийн эмчилгээг даван туулахын тулд зөв харилцаа холбоог бий болгох нь хэрэгтэй.



Та зөв харилцааг хэрхэн бий болгох вэ?

.....

.....

.....

### Бусдын тусламжийг ав

**Сэтгэлийг амар тайван байлгах аргууд:**

- Дуу хөгжим сонсох
- Бусдыг хайрлан хүндэтгэх
- Аз жаргалаа мэдрэх
- Бусдыг сонсох
- Санаа бодлоо бусадтай хуваалцах
- Бусдыг сайшаан магтах
- Инээж баясах
- Шинэ зүйлд суралцах
- Гар урлал хийх
- Ажиглах
- Уучлалт гуйх
- Бусдад туслах

Та сэтгэлийн амар амгаланг олохын тулд юу хийж чадах вэ?

.....

.....

**Сэтгэл амгалан байх нь  
эмчилгээний чухал хэсэг юм**



## ЭМЭНД ТЭСВЭРТЭЙ СҮРЬЕЭГИЙН ЭМЧИЛГЭЭНИЙ ХЯНАЛТ

Эмэнд тэсвэртэй сүрьеэгийн эмчилгээг эмчийн зааврын дагуу бүрэн хийлгэж эдгэрэх нь таны болон танай гэр бүлийн цаашлын амьдралд хамгийн чухал зүйл байх болно.

### Эмчилгээний явцад та дараах зааврыг заавал мөрдөнө

- Өдөр бүр эмч эсвэл сувилагчийн хяналтанд эмээ ууж, тарилгын бэлдмэлийг тариулна.
- Мөн таны бие сайжирч, цэрээр нян гадагшлахгүй болсон үед сайн дурын идэвхтэнээр эмээ зөөлгөж ууж болно.
- Та биеийн жингээ эмчилгээний явцад сар тутам үзэж, тэмдэглэнэ.
- Цэрний түрхэц болон өсгөвөрлөх шинжилгээг эрчимт эмчилгээний шатанд сар тутам, үргэлжлэх шатанд 2 сар тутам 1 удаа өгнө. Шинжилгээний хариуг энэхүү өврийн лавлахын арын нүүрэнд бичиж өөрийнхөө эмчилгээний үр дүнг хянаж байгаарай.
- Цээжний рентген зургийг эмчилгээ эхлэхийн өмнө болон 6, 12, 18, 24 саруудад хийлгэнэ. Та авахуулсан цээжний зургаа сайтар хадгалж эмч нарын зөвлөгөөний хурлаар ороход заавал авч ирнэ.

## ЦЭРНИЙ ШИНЖИЛГЭЭ, ТҮҮНИЙ АЧ ХОЛБОГДОЛ

### Цэрний түрхцийн шинжилгээний ач холбогдол

Цэрний түрхцийн шинжилгээ нь сүрьеэг оношлох, эмчилгээний үр дүнг хянах хамгийн найдвартай арга юм.

### Шинжилгээг ямар нөхцөл авах вэ?

- Цэрийг гадаа гарч авах нь бусдад халдвар тараахгүй байх сайн талтай.
- Гадаа гарах боломжгүй хэвтрийн хүнд шинжилгээг гэрт нь аль болох бусад хүмүүсээс тусгаарлаж аваад, агааржуулалт сайн хийх хэрэгтэй.
- Цэрний шинжилгээг тусгай зориулалтын эргэдэг тагтай саванд авна. Уг савыг эмнэлгээс танд өгнө.

**Шинжилгээг яаж өгөх вэ?**

- Шинжилгээг өгөхийн өмнө амаа буцалсан усаар сайтар зайлна.
- Гүнзгий амьсгал аваад цээжний гүнээс хахирч ханиалган цэрээ гаргана.
- Гаргасан цэрээ шинжилгээний саванд нулимна.
- Цэрний савны гадна талыг цэрээр бохирдуулж болохгүй
- Цэрний савны тагийг сайтар чанга таглана.

**Шинжилгээний цэрийг хаана өгөх вэ?**

- Шинжилгээнд 2 удаагийн цэр авна.
- 1-р цэрийг үзүүлэхээр ирэх үед эмнэлгийн ажилтны хяналтанд
- авч лабораторит хүргүүлнэ.
- 2-р цэрийг та өөрөө авна Зориулалтын савыг гэртээ авч яваад
- өглөө босонгуут цэвэр усаар амаа зайлаад ханиалгаж цэрээ аваад таглаж лабораторит хүргэнэ.

**Шинжилгээний хариу хэзээ гарах вэ?**

- Түрхцийн шинжилгээний хариу 24 цагийн дотор гарна.
- Таныг үзсэн болон хяналтын эмчээс шинжилгээний хариуг авна.

**Онцгой анхааруулга:**

- Цэрийг зөв гаргаж өгөх нь сүрьеэ өвчний оношлогоо, эмчилгээнд нэн чухал.

**Цэр гарахгүй тохиолдолд яах вэ?**

- Цэр гарахгүй тохиолдолд 2 гарын алгыг ар нуруундаа бөөрний харалдаа ташаандаа авсан мэт байрлуулж, хамраар маш гүнзгий 3-4 удаа ойр ойрхон амьсгалж, амьсгалаа амаараа гаргана.
- Энэ үйлдэл нь амьсгалын дээд замыг агаараар цочроож цэр ховхлох сайн арга юм.
- Мөн цэр ховхлох эм ууж болно. Энэ талаар эмчээсээ асууж зөвлөгөө аваарай
- Цэр мөн эсэхийг шалгаж хэмжээ нь хүрэлцээтэй (5 мл-ээс дээш бол) бол савыг сайтар таглана.

## ЭМЭНД ТЭСВЭРТЭЙ СҮРЬЕЭГИЙН ЭСРЭГ ЭМЧИЛГЭЭНИЙ ҮЕД ХОРИГЛОХ ЗҮЙЛ ЮУ ВЭ?

- Эмчилгээний үед архи уухыг хатуу хориглодог. Архи нь эмийн гаж нөлөөг ихэсгэж, бүрэн эдгэрэх боломжийг алдагдуулж болзошгүй байдаг. Эмчилгээ тасалж байгаа хүмүүсийн ихэнх нь архины асуудалтай байдаг.
- Тамхи татах нь эрүүл хүний биед ч хортой байдаг тул ядарч сульдсан уушгиа улам хордуулах хэрэггүй бөгөөд хэрэв та тамхи татдаг бол өдөрт татах тамхины тоог цөөрүүлэх байдлаар тамхины хамаарлаас гарч болно.
- Хоол хүнсний талаас хориглох зүйл байхгүй бөгөөд амин дэм, илчлэг сайтай хоол хүнс хэрэглэж, сайтар унтаж амарч байх нь өвчний эдгэрэлтэнд сайнаар нөлөөлнө. Шингэн зүйл сайтар уух хэрэгтэй.



### Онцгой анхааруулга:



- Эмчилгээний явцад олон хоногоор эмийг гэртээ авах талаар эмч, сувилагч нарт санал болгох, элдэв зовлон тоочих нь зохисгүй гэдгийг анхаарах хэрэгтэй.
- Эмч сувилагчийн хяналтанд өдөх бүр тариа тариулж, эмээ ууснаар Та эдгэрэх боломжтой.

### Та дараах зааврыг заавал мөрдөнө.

- Та гэр бүл, найз нөхөд, хамаатан садан, нийгэм хамт олонд халдвар тараахаас сэргийлэх хамгийн шилдэг арга бол эмчийн зааврын дагуу бүх эмээ горимын дагуу уух явдал юм.
- Та эмчилгээний хяналтын шинжилгээг цаг тухай бүрд өгч эмчийн заасан цагт тогтмол үзүүлж байх нь таны өвчний явц ямар байгааг хянах ач холбогдолтой.
- Уушгины зураг авахуулж, цэрний түрхэц болон өсгөвөрлөх шинжилгээг өгөх нь сүрьеэгийн эсрэг хоёрдугаар эгнээний эмүүд танд хэрхэн үйлчилж байгааг хянах гол арга юм. Энэ нь та бусдад халдвар тарааж байгаа эсэхийг мэдэх боломжтой.
- Гэр бүлийн гишүүдээ эмчилгээний эхний 2 жилд 6 сар тутамд 1 удаа үзлэгт хамруулах ёстой.

## ЭМЧИЛГЭЭНИЙ ЯВЦАД АЖИЛ, СУРГУУЛИА ХЭРХЭН ЗОХИЦУУЛАХ ВЭ?



- Эмэнд тэсвэртэй нянгийн халдвар ялгаруулж байгаа үед ажил хийх, хичээл сургуульд явахыг хатуу хориглодог. Энэ нь таныг ялгаварлан гадуурхаж байгаа хэрэг биш бөгөөд бусад хүмүүсийн эрүүл мэндийг хамгаалах зорилготой юм.
- Эмчилгээ хийлгэж байгаа хугацаанд 150 хоног хүртэл эмнэлгийн хуудас авах эрхтэй.
- Эмэнд тэсвэртэй сүрьеэгээр өвчилж эмчилгээ хийлгэж байгаа 9-24 сарын хугацаанд таны хөдөлмөрийн чадвар алдалтын магадлагааг харьяа аймаг, дүүргийн сүрьеэгийн диспансер зохицуулж өгнө.
- Хичээлээ таслахгүйн тулд зайнаас суралцах талаар сургууль, багш нартайгаа тохирч болно.

## ГЭРИЙН НӨХЦӨЛД БАРИМТЛАХ ДЭГЛЭМ

Та эмэнд тэсвэртэй сүрьеэгээр өвчилсөн бол эмнэлэгт хэвтэж эрчимт шатны эмчилгээ хийлгэх нь бусдад халдвар тараахгүй байх цорын ганц боломж юм. Хэрэв та ямар нэг шалтгааны улмаас эмнэлэгт хэвтээгүй диспансер, өдрийн эмчилгээний цэгээр эрчимт шатны эмчилгээ хийлгэж байгаа бол дараах зааврыг дагана уу.

- Эмч, сувилагчийн хяналтанд өдөр бүр эмээ тууштай уух
